



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бугат сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/6/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2022 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас:70342580 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: П.Мөнхтуяа Утас: 70342716 Цахим хаяг: MonkhtuyaP@audit.gov.mn</p> <p>Аудитор: Утас: 70342716 Цахим хаяг:</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5-18
3. Аудитын тайлан.....	18-20
3.1 Ерөнхий зүйл.....	
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	
3.4 Материаллаг байдал.....	
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	
3.8 Аудитын гол асуудал.....	
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	
4. Аудитын илрүүлэлт.....	20-22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
МУЗГ	Монгол улсын Засгийн газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.08.25 № 012
танай _____ ны № _____ т

БУГАТ СУМЫН ЭМТ-ИЙН
ДАРГА Ж.СЭРГЭЛЭН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бугат сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бугат сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.АНХБАЯР



006020301

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>68,658,337.23</u>	<u>192,626,039.87</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	11,289,269.36
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	11,289,269.36
3121	Төгрөг	-	11,289,269.36
31211	Төрийн сангийн харилцах	-	11,119,477.92
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	169,791.44
33	АВЛАГА	10,217,017.57	71,588,528.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	132,849.57	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	62,832,800.00
335	Бусад авлага	10,084,168.00	8,755,728.00
3351	Байгууллагаас авах авлага	10,079,790.00	8,751,350.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	4,378.00	4,378.00
35	БАРАА МАТЕРИАЛ	58,441,319.66	109,748,242.51
351	Түүхий эд материал	20,546,957.09	61,111,539.94
35130	Эм боох материал	20,546,957.09	61,111,539.94
354	Хангамжийн материал	37,894,362.57	48,636,702.57
35410	Бичиг хэргийн материал	739,500.00	928,500.00
35420	Аж ахуйн материал	31,574,759.95	40,825,039.95
35440	Түлц, шатах тослох материал	2,895,545.22	5,651,545.22
35460	Хүнсний материал	2,684,557.40	1,231,617.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>665,085,257.58</u>	<u>672,848,737.96</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	665,085,257.58	672,848,737.96
392	Биет хөрөнгө	648,785,257.58	655,451,862.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	569,848,819.53	569,848,819.53

Бугат сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

39202	Хуримтлагдсан элэгдэл	(30,130,580.88)	(48,445,871.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	76,583,411.49	79,083,411.49
39204	Хуримтлагдсан элэгдэл	(25,347,411.39)	(34,757,244.66)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	61,424,848.80	100,280,021.13
39206	Хуримтлагдсан элэгдэл	(22,650,275.83)	(32,935,850.52)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,191,266.91	31,531,166.91
39208	Хуримтлагдсан элэгдэл	(6,800,973.80)	(12,464,741.99)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,617,328.00	3,617,328.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(404,000.16)	(808,000.32)
39217	Ном	452,824.91	502,824.91
393	Биет бус хөрөнгө	16,300,000.00	17,396,875.00
39301	Програм хангамж	600,000.00	1,950,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(600,000.00)	(853,125.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,300,000.00	16,300,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	<u>733,743,594.81</u>	<u>865,474,777.83</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>100,357.96</u>	<u>1,508,084.94</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	100,357.96	1,508,084.94
413	Өглөг	100,357.96	1,508,084.94
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	100,000.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	30,121.96	1,337,848.94
4136	Бусад өглөг	70,236.00	70,236.00
41361	Байгууллагад төлөх өглөг	70,236.00	70,236.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>733,643,236.85</u>	<u>863,966,692.89</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	733,643,236.85	863,966,692.89
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	380,957,616.09	380,957,616.09
51101	Өмч: - төрийн	380,957,616.09	380,957,616.09
512	Хуримтлагдсан үр дүн	(2,131,330.34)	128,192,125.70
51210	Өмнөх үеийн үр дүн	(2,131,330.34)	(2,131,330.34)

51220	Тайлант үеийн үр дүн	-	130,323,456.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	354,816,951.10	354,816,951.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>733,743,594.81</u>	<u>865,474,777.83</u>

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	471,486,743.64	807,853,276.97
11	ТАТВАРЫН ОРЛОГО	59,410,608.64	194,080,729.17
110	Орлогын албан татвар	59,410,608.64	194,080,729.17
1100	Хувь хүний орлогын албан татвар	59,410,608.64	194,080,729.17
110003	Хөрөнгийн орлого	48,859,000.00	31,770,272.33
110004	Хөрөнгө борлуулсны орлого	10,551,608.64	162,310,456.84
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,637,525.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	23,337,525.00	-
120001	Хувьцааны ногдол ашиг	82,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,105,525.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	23,105,525.00	-
120005	Түрээсийн орлого	150,000.00	-
122	Тусламжийн орлого	300,000.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	300,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	388,438,610.00	613,772,547.80
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	294,111,700.00	342,387,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	294,111,700.00	342,387,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,918,600.00	195,344,485.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,918,600.00	195,323,085.00

Бугат сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	21,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	54,822,800.00	55,556,454.80
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	54,822,800.00	55,556,454.80
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	18,585,510.00	20,484,508.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	18,585,510.00	17,032,664.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	-	3,451,844.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	411,835,586.37	677,529,820.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	411,835,586.37	677,529,820.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	407,740,878.33	630,999,820.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	237,624,763.43	261,019,799.13
210101	Үндсэн цалин	153,809,530.43	165,929,195.57
210102	Нэмэгдэл	68,245,449.00	64,145,824.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,046,000.00	-
210104	Урамшуулал	14,523,784.00	30,944,779.56
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,609,520.96	32,912,564.86
210201	Тэтгэврийн даатгал	21,353,253.98	24,141,535.89
210202	Тэтгэмжийн даатгал	2,362,378.10	2,424,054.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,879,820.27	1,925,803.28
210204	Ажилгүйдлийн даатгал	455,824.24	401,924.54
210205	Эрүүл мэндийн даатгал	4,558,244.37	4,019,247.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,158,467.00	52,817,704.80
210301	Гэрэл, цахилгаан	2,279,922.00	2,485,000.00
210302	Түлш, халаалт	49,501,620.00	49,498,880.00
210303	Цэвэр, бохир ус	376,925.00	833,824.80
2104	Хангамж, бараа материалын зардал	16,207,843.00	16,252,760.00
210401	Бичиг хэрэг	2,121,623.00	2,240,800.00
210402	Тээвэр, шатахуун	9,288,000.00	9,433,300.00

Бугат сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,478,730.00	1,479,140.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,482,750.00	2,928,020.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	836,740.00	171,500.00
2105	Нормативт зардал	35,456,723.12	220,431,075.19
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	29,920,633.72	206,972,272.19
210502	Хоол, хүнс	4,939,089.40	13,458,803.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	597,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,118,700.00	556,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	330,600.00	4,000.00
210604	Урсгал засвар	1,788,100.00	552,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,427,600.00	1,108,100.00
210702	Дотоод албан томилолт	1,427,600.00	1,108,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,049,630.00	394,425.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	617,630.00	261,175.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	58,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	40,250.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	35,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,087,630.82	45,507,391.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,530,796.00	1,175,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,556,834.82	44,331,591.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,094,708.04	46,530,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	760,000.00	46,530,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	25,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	760,000.00	21,130,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	390,033.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	390,033.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,944,675.04	-

213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,944,675.04	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>59,651,157.27</u>	<u>130,323,456.04</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>59,651,157.27</u>	<u>130,323,456.04</u>

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>388,588,610.00</u>	<u>552,268,187.80</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	150,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	150,000.00	-
120005	Түрээсийн орлого	150,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	388,438,610.00	552,268,187.80
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	294,111,700.00	342,387,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	294,111,700.00	342,387,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,918,600.00	132,511,685.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,918,600.00	132,490,285.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	21,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	54,822,800.00	55,556,454.80
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	54,822,800.00	55,556,454.80
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	18,585,510.00	21,812,948.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	18,585,510.00	18,361,104.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	-	3,451,844.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>386,305,610.00</u>	<u>520,654,118.44</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	386,305,610.00	520,654,118.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	380,882,461.96	474,024,118.44

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	236,711,613.00	260,886,949.56
210101	Үндсэн цалин	153,942,380.00	165,796,346.00
210102	Нэмэгдэл	68,245,449.00	64,145,824.00
210104	Урамшуулал	14,523,784.00	30,944,779.56
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,609,520.96	32,912,564.86
210201	Тэтгэврийн даатгал	21,353,253.98	24,141,535.89
210202	Тэтгэмжийн даатгал	2,362,378.10	2,424,054.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,879,820.27	1,925,803.28
210204	Ажилгүйдлийн даатгал	455,824.24	401,924.54
210205	Эрүүл мэндийн даатгал	4,558,244.37	4,019,247.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,584,367.00	52,817,704.80
210301	Гэрэл, цахилгаан	2,279,922.00	2,485,000.00
210302	Түлш, халаалт	49,501,620.00	49,498,880.00
210303	Цэвэр, бохир ус	802,825.00	833,824.80
2104	Хангамж, бараа материалын зардал	15,175,830.00	19,627,377.22
210401	Бичиг хэрэг	1,496,550.00	2,231,360.00
210402	Тээвэр, шатахуун	8,457,650.00	12,189,377.22
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,478,730.00	1,479,140.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,815,300.00	2,822,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	927,600.00	905,000.00
2105	Нормативт зардал	37,454,141.00	100,838,157.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,436,661.00	84,013,794.00
210502	Хоол, хүнс	4,061,580.00	11,998,863.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,955,900.00	4,825,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,482,800.00	1,520,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	634,400.00	132,000.00
210604	Урсгал засвар	1,848,400.00	1,388,750.00
2107	Томилолт, зочны зардал	1,427,600.00	1,108,100.00

210702	Дотоод албан томилолт	1,427,600.00	1,108,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,049,630.00	394,425.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	617,630.00	261,175.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	58,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	40,250.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	35,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,386,960.00	3,918,090.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,386,960.00	3,918,090.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,423,148.04	46,630,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	760,000.00	46,630,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	25,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	760,000.00	21,230,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,328,440.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,328,440.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	390,033.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	390,033.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,944,675.04	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,944,675.04	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>2,283,000.00</u>	<u>31,614,069.36</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,283,000.00	20,324,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,283,000.00	20,324,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,283,000.00	20,324,800.00
222001	Тоног төхөөрөмж	2,238,000.00	18,924,800.00
223001	Бусад хөрөнгө	45,000.00	1,400,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(2,283,000.00)</u>	<u>(20,324,800.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(0.00)	11,289,269.36

10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	11,289,269.36
----	---	---	---------------

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	380,957,616.09	354,816,951.10	(62,446,487.61)		673,328,079.58
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	380,957,616.09	354,816,951.10	(62,446,487.61)	-	673,328,079.58
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	60,315,157.27		60,315,157.27
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	380,957,616.09	354,816,951.10	(2,131,330.34)	-	733,643,236.85
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	380,957,616.09	354,816,951.10	(2,131,330.34)	-	733,643,236.85
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	380,957,616.09	354,816,951.10	(2,131,330.34)	-	733,643,236.85

D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	130,323,456.04	130,323,456.04
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	380,957,616.09	354,816,951.10	128,192,125.70	-

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	387700200.00	407308584.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	387700200.00	393728784.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	387100200.00	392968784.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	238749000.00	243844081.00
210101	Үндсэн цалин	143935800.00	165796346.00
210102	Нэмэгдэл	74292400.00	64145824.00
210104	Урамшуулал	20520800.00	13901911.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33452100.00	32493412.86
210201	Тэтгэврийн даатгал	24219800.00	23722383.89
210202	Тэтгэмжийн даатгал	2549400.00	2424054.07

Бугат сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210203	ҮОМШӨ-ний даатгал	2039500.00	1925803.28
210204	Ажилгүйдлийн даатгал	425700.00	401924.54
210205	Эрүүл мэндийн даатгал	4217700.00	4019247.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41662800.00	52817704.80
210301	Гэрэл, цахилгаан	2285000.00	2485000.00
210302	Түлш, халаалт	37127800.00	49498880.00
210303	Цэвэр, бохир ус	2250000.00	833824.80
2104	Хангамж, бараа материалын зардал	18540000.00	18222977.22
210401	Бичиг хэрэг	1212500.00	2045160.00
210402	Тээвэр, шатахуун	11953400.00	11021177.22
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,486,800.00	1,429,140.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,587,300.00	2,822,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,300,000.00	905,000.00
2105	Нормативт зардал	35,089,000.00	39,097,344.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24,800,000.00	28,251,844.00
210502	Хоол, хүнс	7,279,000.00	7,940,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,010,000.00	2,905,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,000,000.00	1,520,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,500,000.00	132,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,388,750.00
2107	Томилолт, зочны зардал	1,700,000.00	660,000.00
210702	Дотоод албан томилолт	1,700,000.00	660,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,724,500.00	394,425.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,700,000.00	261,175.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	58,000.00	58,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,000.00	40,250.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	35,000.00	35,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,350,000.00	-
210807	Газрын төлбөр	40,500.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,182,800.00	3,918,090.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,182,800.00	3,918,090.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	600,000.00	760,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	600,000.00	760,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	760,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	13,579,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	13,579,800.00
222001	Тоног төхөөрөмж	-	12,179,800.00
223001	Бусад хөрөнгө	-	1,400,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	414,976,218.80
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	342,387,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	342,387,100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	55,556,454.80
132001	Орон нутгийн төсвөөс	-	55,556,454.80
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	17,032,664.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	17,032,664.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		11,119,477.92

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	133,670,333.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	126,925,333.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	81,055,333.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	17,042,868.56
210104	Урамшуулал	17,042,868.56
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	419,152.00
210201	Тэтгэврийн даатгал	419,152.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,404,400.00
210401	Бичиг хэрэг	186,200.00
210402	Тээвэр, шатахуун	1,168,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	50,000.00
2105	Нормативт зардал	61,740,813.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	55,761,950.00
210502	Хоол, хүнс	4,058,863.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,920,000.00
2107	Томилолт, зочны зардал	448,100.00
210702	Дотоод албан томилолт	448,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,870,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,870,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	25,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,470,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,745,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,745,000.00
222001	Тоног төхөөрөмж	6,745,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	132,511,685.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	132,511,685.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	132,490,285.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,400.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	169,791.44

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бугат сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлан, бүртгэлд гарсан алдаа зөрчилтэй, холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Бугат сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Бугат сумын ЭМТ нь “Хүн амд анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх чиг үүрэг” бүхий зорилго тавьж ажиллажээ. 2021 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 92%, МУЗГ-ын тогтоолоор батлагдсан үндэсний 14 хөтөлбөр хэрэгжиж биелэлт 90%-ийн үзүүлэлтэй тус тус дүгнэгдэж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагыг хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар болон дотоод аудитын нэгжгүй болно. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бугат сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт хөрөнгийн 733.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 14.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 11.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бугат сумын ЭМТ нь 2021 оны санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 388 дугаар журмын 3-р хавсралтын дагуу бэлтгэж тайлагнасан байна. Үүнд: Санхүү байдлын, Үр дүнгийн, Мөнгөн гүйлгээний, Өмчийн өөрчлөлтийн тайлангууд, санхүүгийн тодруулга тайлангуудын өөрчлөлт, нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримтлан, НБББ, санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнгийн талаар болзошгүй өр төлбөр, авлагыг зэргийг тодруулж тайлагнасан болно.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Бугат сумын ЭМТ нь 2021 онд улсын төсвөөс 342.4, ЭМДС-гаас 21.0, орон нутгийн төсвөөс 55.7 сая төгрөг буюу нийт 419.1 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тус сумын ЭМТ нь 2021 он улсын төсвөөс 342.4, орон нутгийн төсвөөс 55.6, ЭМДСангаас 133.8, нэмэлт дансаар 20.5 сая төгрөг буюу нийт 552.3 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 541.0 сая төгрөгийг зарцуулж, мөнгөн гүйлгээний тайлангаар 11.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Бугат сумын ЭМТ нь 2021 онд нэмэлт дансаар нийт 133.8 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 133.6 сая төгрөгийг зарцуулж 0.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Бугат сумын ЭМТ нь ковид буюу цар тахалтай холбогдуулаад ЭМС-ийн 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/496, 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/585 тоот тушаалуудыг үндэслэн тэтгэмж урамшуулалын зардалд 26.6 сая төгрөг олгожээ.

Хандив тусламжаар ЭМЯ болон ЭМГ-аас 31.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, эм боох болон хамгаалах хэрэгслийн 162.3 сая төгрөгийн бараа материалыг тус тус орлогод авч тайлагнажээ.

Хэвтэн эмчлүүлсэн, дархлаажуулалтын 62.8 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тодруулга тайланд бүрэн тусгаж 1.5 сая төгрөгийн өглөгтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй алдаа зөрчил илрээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тус сумын ЭМТ-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулж ажиллахдаа аудитын төлөвлөлтийн үе шатанд сонгосон нийт 12 эрсдэлийн хүрээнд горим сорилыг хэрэгжүүлэн ажиллалаа.

Хэрэгжүүлсэн горим сорилоор тушаал шийдвэргүйгээр нэмэгдэл, цалин, мөнгөн тэтгэмж олгосон, харилцагч байгууллагатай тооцоо нийлж ажиллаагүй, томилолтын илтгэх хуудас, тайланг хүн тус бүрээр гаргаж тайлагнаагүй, шатахуун зарцуулалтыг зарцуулснаар тайлагнаагүй, жолоочийн тооцооны замын хуудсыг дутуу хөтөлсөн, анхан шатны баримтын бүрдэл дутуу, няравын тайлагнасан эмийн тайлангийн дүн, бараа материалын тодруулга тайлангийн дүнгээс зөрүүтэй зөрчлүүд илэрч байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Үүний дагуу байгууллагын мэдээллийг шилэн дансанд бүрэн мэдээлсэн боловч 2021 оны байдлаар 14 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байгаа ч хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил илэрсэн нь холбогдох хуулийн шалгуурт бүрэн нийцэхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар 2 зөвлөмж өгч ажилласнаас зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 24 тоот албан бичгээр хүргүүлж ажиллажээ.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

2022 онд гүйцэтгэлээрээ санхүүжиж байгаатай холбогдуулан өөрийн үйл ажиллагааны орлого, болон гүйцэтгэлийг авч үзэх нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт 1, 5.0 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 3.2 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгч ажиллалаа.

4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа гараагүй болно.

4.2 Төлбөрийн акт

Тус сумын ЭМТ-ийн 2021 оны нэмэгдэл цалин, тэтгэмж урамшууллын зардлыг түүвэрлэн шалгахад тушаал шийдвэргүйгээр 1700145 төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6

дугаар зүйлийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

1.Тус сумын ЭМТ-ийн 2021 оны шатахуун зарцуулалтыг түүвэрлэн шалгахад 2895545 төгрөгийн шатахуун зарцуулалтыг данс бүртгэлээс хасаагүй, жолоочийн тооцооны хуудас хөтлөөгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу бүрдүүлж ажилласан нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага бичлээ.

2. Тус сумын ЭМТ-ийн 2021 оны няравын тайлагнасан эмийн орлого, зарлагын дүнг бараа материалын тодруулга тайлангийн дүнтэй тулгахад эмийн зарлагыг 2088983 төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, эмийн зарцуулалтын тайланг үнэн зөв тайлагнаагүй нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага бичлээ.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлага, өглөгийн зардалтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Авлага, өглөгийн тодруулга тайлангийн 1.4 сая төгрөгийн үлдэгдлийг харилцагч байгууллага иргэдтэй тооцоо нийлж, баталгаажуулж ажиллаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6.”эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэсэн заалтыг мөрдлөгөө болгож ажиллах.

2. Дотоод албан томилолтын зардалтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Албан томилолтоор ажилласан ажилчдаас илтгэх хуудас тайланг хүн тус бүрээр нь анхан шатны баримтыг бүрдүүлж ажиллаагүй, нэг жил тайланг хавсаргасан зөрчил илэрлээ.

Өгсөн зөвлөмж:

НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

3. Тэтгэмж урамшуулалтай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тушаал шийдвэрэгүйгээр 1.4 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах.

4. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Шилэн дансанд мэдээлэх мэдээлээс 14 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд мэдээлэх мэдээлийг цаг хугацаанд нь хоцроохгүй мэдээлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 02 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/ д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Бугат сумын ЭМТ	7	9.9	0	0	1	1.7	2	5.0	4	3.2

/сая/төгрөгөөр/

